

**ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Төсөв, зардал /мян.төг/	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1	Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, ажлын тайлан, мэдээг байгууллагын цахим хаягт байршуулж, олон нийтэд хүргэх	Авлигын эсрэг хууль тогтоомжоор төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг хэрэгжсэн, иргэд, алба хаагчид мэдээлэлтэй болсон байна	Зардал шаардахгүй	I-XII сар	Тамгын хэлтэс
2	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үнэлгээ хийн Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээ бодитой хэрэгжсэн байна	Зардал шаардахгүй	2021 оны I сар	Тамгын хэлтэс Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
3	Хил хамгаалах байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг гаргаж, дүгнэх хуудасны дагуу дүгнэн хавсаргаж Авлигатай тэмцэх газарт хүргэх	Төлөвлөсөн арга хэмжээг зураг, тоон үзүүлэлт, дүрс, бичлэгээр баримтжуулан тайланг хугацаанд тайлагнасан байх	Зардал шаардахгүй	VI/15-ны дотор	Тамгын хэлтэс
				XII/15-ны дотор	Тамгын хэлтэс
4	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тогтмол ажиллагаатай байлгах, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн материалыг байршуулах	Авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээ, мэдээлэлтэй алба хаагчид тухай бүр танилцсан байна	Зардал шаардахгүй	I-XII сар	Тамгын хэлтэс
5	Бие бүрэлдэхүүний онол, эрх зүйн сургалтын хөтөлбөрт Авлигын эсрэг хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг тусган сургалт мэдээлэл, яриа таниулга хийх, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад нийтийн албан тушаалтнуудыг хамруулах	Алба хаагчдын зүгээс хууль тогтоомжийг судалж мэдсэн, үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна	Зардал шаардахгүй	I-XII сар	Тамгын хэлтэс Хүний нөөцийн хэлтэс
6	Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэм, холбогдох журмууд, хүний нөөцийн бодлогыг байгууллагын цахим хуудсанд байршуулах, тухай бүр шинэчлэх	-Хууль, тогтоомж хэрэгжсэн байна	Зардал шаардахгүй	III сар	Сургалтын хэлтэс

7	Албан тушаалтныг дэвшүүлэх, нөөцөд авах, шилжүүлэн томилох, суралцуулах асуудлын ил тод байдлыг хангах, Хил хамгаалах байгууллагад шаардлагатай тусгай мэргэжлийн болон сул орон тоонд хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонгон шалгаруулалт явуулах, нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх, Засгийн газраас баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан томилгоо хийх	-Хүний нөөцийн ил тод байдал хангагдсан байна -Төрийн албаны тухай хууль хэрэгжсэн байна	Зардал шаардахгүй	I-XII cap	Хилийн анги, тусгай салбарын захирагч
8	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдүүдийн ХАСУМ-ийг АТГ-т хянуулж, хянасан байдлыг үндэслэн томилох	Хуулийн хэрэгжилт хангагдана	Зардал шаардахгүй	I-XII cap	
9	ХАСХОМ гаргах үүрэг бүхий нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлагыг хилийн анги, тусгай салбаруудад хүргэх	Хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөл бүрдэнэ	Зардал шаардахгүй	II-III cap	
10	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах тухай албан бичгийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулж, хариу тайланг хугацаанд нь хүргүүлэх	Авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлнэ	Зардал шаардахгүй	I-XII cap	Удирдлага, Тамгын хэлтэс, Анги, салбарын захирагч нар
11	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг тодорхойлох, эрсдэлийг хянах, авлига гарах нөхцөлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлнэ	Зардал шаардахгүй	I-XII cap	Удирдлага, Тамгын хэлтэс, Анги, салбарын захирагч нар
12	Байгууллагын дотоодод чиглэсэн, албан хаагчдын эрх ашгийг хөндсөн, хэм хэмжээ тогтоосон баримт бичгийн төслийг боловсруулахдаа ХХЕГ-ын бүтцийн нэгжийн газар, хэлтэс, хилийн анги, тусгай салбарын саналыг тусгах	Байгууллагын ил тод байдал хангагдаж, Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, "Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах тухай"	Зардал шаардахгүй	I-XII cap	Газар, хэлтэс, албадын дарга нар
13	Гадагш чиглэсэн, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэх	Засгийн газрын тогтоолын холбогдох заалтууд хэрэгжсэн байна	Зардал шаардахгүй		Газар, хэлтсийн дарга нар, Тамгын хэлтэс
14	Хил хамгаалах байгууллагаас олгож буй зөвшөөрөл, лавлагаа авахад шаардлагатай материалыг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд шуурхай үйлчлэх	Байгууллагын ил тод, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдана	Зардал шаардахгүй	I-XII cap	Тамгын хэлтэс, Холбоо мэдээллийн

			Зардал шаардахгүй		технологийн хэлтэс
15	Хил хамгаалах байгууллага, хилчдийн үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэдэд чиглэсэн эрх зүйн сурталчилгааг төлөвлөн хэрэгжүүлэх	-Төрийн үйлчилгээний чанар сайжирч, хүнд суртал чирэгдэл багасна -Байгууллагын нэр хүнд дээшилнэ		I-XII cap	СМСС-ны хэлтэс, Тамгын хэлтэс
16	Хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагаатай хүүхэд, залуучуудыг танилцуулах	Улсын хил хамгаалалт, Хилийн алба, хил хамгаалах үйл ажиллагааны талаар мэдлэг олгоно	Зардал шаардахгүй	I-XII cap	Хилийн анги, тусгай салбарын захирагч нар, Хилийн түүхийн музей
17	Санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраар тайлангийн аудит хийлгэж нууцад хамааралгүй дүгнэлт, зөвлөмжийг нийтэд мэдээлэх	Төсвийн тухай хууль хэрэгжинэ	Зардал шаардахгүй	II-III cap	Санхүүгийн хэлтэс
18	Төсвийн ерөнхийлөн захирагч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн яамны төрийн сангийн газарт төсвийн гүйцэтгэл, биелэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулах			I-XII cap	
19	Хил хамгаалах байгууллагаас байгууллага, хуулийн этгээд, иргэнтэй аливаа гэрээ байгуулахдаа авлигаас ангид байх урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийн	Зардал шаардахгүй	I-XII cap	Тамгын хэлтэс Төлөвлөлт хангалтын хэлтэс
20	Хил хамгаалах байгууллагын цэргийн алба хаагчдын нормын хувцас, хэрэглэлийг бэлтгэх үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, тушаалын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан, аудитын тайлан, дүгнэлт, бусад хяналт шалгалтын дүнг бие бүрэлдэхүүнд мэдээлэх, нууцад хамаарахгүй мэдээллийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	Хууль тогтоомж хэрэгжиж, шударга байдал хангагдана.	Урсгал зардлаас	I-XII cap	Төлөвлөлт хангалтын хэлтэс

21	Тендерийг хууль тогтоомжийн хүрээнд зарлах, зохион байгуулах				
22	Тендерийн үнэлгээний хороонд Хууль зүй, дотоод хэргийн яам, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах			I-III сар	
23	Тендерийн үнэлгээний хорооны комиссын гишүүд, өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй эсэхээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулах, тайлбар мэдэгдлийг https://meduuleg.iaac.mn цахим системд байрлуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан байна	Зардал шаардахгүй	I-XII сар	Төлөвлөлт хангалтын хэлтэс, ЭБАТ-ууд
24	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлөөс сэргийлэх, зөрчлийг бүртгэх, хянан шалгах, шийдвэрлэх ажиллагааг идэвхжүүлэх	Хамт олны дунд ёс зүйтэй, эерэг уур амьсгал бүрдсэн байна	Зардал шаардахгүй	I-XII сар	СЗМСС-ны хэлтэс, Ёс зүйн хороо
25	Иргэн, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх				
26	Шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээллийн мөрөөр албаны шалгалт явуулах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Иргэдийн эрх ашиг хамгаалагдана	Зардал шаардахгүй	I-XII сар	Удирдлага, Тамгын хэлтэс, Хилийн анги, тусгай салбарын захирагч нар
27	Хил хамгаалах байгууллагаас байгууллага, иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг цахимжуулах	Шат дамжлага буурч, түргэн шуухай байдал нэмэгдэнэ	30 сая төгрөг	III-XII сар	Удирдлага, Тамгын хэлтэс Холбоо, мэдээллийн технологийн хэлтэс
28	Шилэн дансны болон мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж нууцад хамаарахгүй мэдээ мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, байршуулах	Иргэний мэдээлэл авах эрх, ил тод нээлттэй байдал хангагдсан байна.	Зардал шаардахгүй		Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Санхүүгийн хэлтэс

29	Хил хамгаалах байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх, хилийн анги, харьяа улсын үйлдвэрийн газар, ХХЕГ-ын санхүүгийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийх	Шударга, нээлттэй, ил тод байдал хангагдаж байгууллагын үйл ажиллагааны үр дүнд эерэг нөлөө үзүүлнэ	Урсгал зардлаас	I-XII сар	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
30	Хяналт шалгалт явуулсан дүнгийн тухай нотломж, илтгэх хуудсыг ХХЕГ-ын даргын зөвлөлд танилцуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах, дүнг бие бүрэлдэхүүнд мэдээлэх, сургалт зохион байгуулах			Тухай бүр	

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР